



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/248

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтад батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбай /5 газарт/" ажлын гэрээг "Мандал шилтгээн" ХХК-тай 473,612,256 (дөрвөн зуун далан гурван сая зургаан зуун арван хоёр мянга хоёр зуун тавин зургаа) төгрөгийн үнийн дүнгээр байгуулсугай.
2. Батлагдсан зураг, төсвийн дагуу "Жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбай /5 газарт/"-н ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Мандал шилтгээн" ХХК (Б.Ням)-д үүрэг болгосугай.
3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823100667